

ТӨРТ ЁСНОО ЭРДМИЙГ ДЭЭДЛЭХ ҮЗЭЛ

С. Дашдэжид *

Монголын төрт ёсны уламжлалд эрдэм номыг эрхэмлэн дээдлэх, эрдэмт мэргэдийг хүндэтгэх, сэцэн билигтнийг сонгон хаан ор залгамжлуулах тогтсон дэг жаягтай байжээ. Энэхүү тасарч үл болох жаяг ёсыг чандлан баримталж, төрийн албыг чин шударгаар хашиж, төр түмнийхээ төлөө хоёргүй сэтгэлээр хүчин зүтгэх сэцэн билигт хаад, ихэс дээдэс, мэргэн түшмэл, сайд нарыг сонгон шалгаруулж хүчирхэг төрт улсийг төвхнүүлдэг эрхэм уламжлал нь бидний өвөг дээдэс эрдэм ухаан, оюун билгийг шүтэн, үр хүүхдүүддээ аливааг ухааран ойлгох болсон үеэс сургаал үгээ хэлж, цээжлүүлэн тогтоолгож, эрдэм билигт хүмүүн болгох гэрийн хүмүүжилтэй салшгүй холбоотой.

Ухаант сэцэн Өүлэн эх урьдын Алунгуа эхийн таван хөвгүүдээр үлгэрлэн, “эртний үгийг *иш татаж, өвгөдийн үгийг үндэс болгон*” [Ш.Чоймаа, 2012, 70]¹ ирээдүйн их хаад, гарамгай удирдагч, цэргийн жанжидыг сурган хүмүүжүүлж, бүхнийг хураан, эзэнт гүрнийг байгуулж төрийг төвшитгөн, ард түмнийг амаржуулан жаргаахад эв эе, эрдэм номын хүч чухал болохыг ухааруулан өсгөсөн билээ.

Их Монгол улс байгуулагдсан явдал монгол туургатны үндэсний ухамсарыг сэргээн шинэлэг үзэл санаа төлөвшин тогтох, хэл соёл, ахуй заншил ойртон төр ёсны боловсрол хөгжих аятай орчинг бүрдүүлжээ. Чингис хаан уйгуржин бичгийг төрийн бичиг болгож Найманы бичгийн сайд Тататунгаагаар өөрийн хөвгүүд ба язгууртны хүүхэд ах дүү нарт уг бичгийг заалгаж гүрний “Их засаг” гэх бичмэл хуультай болсон нь монголын нийгмийн дотор гарсан дэвшилт алхам болов. [Д.Наран, 2001, 25]² Энэхүү дэвшил нь эрдэм ухааныг түгээн дэлгэрүүлэх, нийт ард түмнийг гэгээрүүлэх, харь улстай харилцах боломжуудыг бий болгожээ. Тэр үеийн мэдлэг боловсролыг гэрийн нөхцөлд өдөр тутмын ахуй амьдралын цаг заваар зааж сургах хэлбэр зонхилох шинжтэй байсан бөгөөд Өгэдэй хааны үед хааны хөвгүүд ач гуч, төрийн түшээ эрдэмт хүмүүнийг сургах, бэлтгэх “гэр сургууль” байгуулагджээ.

Ийнхүү эзэнт гүрнийг байгуулж төрийг төвшитгөн, ард түмнийг амаржуулан жаргааж, улс нийгмээ мандуулан хөгжүүлэхэд цэргийн эрдмээс илүү бичгийн эрдмийг чухалчлан үзэж, төрд алба хаших түшмэл хүнийг илүү хүндэтгэх, эрдэм номтой, ухаан билиг хурц төгөлдөр хүнийг эрхэмлэн дээдлэдэг байж. Улмаар “Хаан хүний 35 эрдэм”³,

* МУИС, Утга зохиол, урлаг судлалын тэнхим

¹ Ш.Чоймаа (2012), Тэмүжин хөвгүүнээс тэнгэрлэг эзэнд, Улаанбаатар.

² Д.Наран (2001), Монголын төр ёсны боловсролын түүх, Улаанбаатар, 25-р тал.

³ Ш.Чоймаа (2006), Оюунтүлхүүр нэрт шастир, *эхийг харгуулан, кирилл үсэгт хөрвүүлж, тайлбар хийв*, Улаанбаатар, 70-р тал.

“Түшмэл хүний 9 эрдэм”⁴, “Долоон их бин”⁵ зэрэг үнэлэмж, шалгуураар төрийн хүнийг шинжих, таних, боловсруулан сургаснаар хамгийн эрдэм төгс, үнэн шадарга, элбэрэл тахимдуу, эрдэмт нэгнийг олж төрийн их хэрэгт хүчин зүтгүүлдэг уламжлалтай билээ.

Эзэн богд өтгөс өвгөд, эрдэмтэн мэргэд, шадар зөвлөх, сайд нар төдийгүй цэцэн ухаант эгэл энгийн ардуудын гүн утгат, цэцэн үгсийг ихэд сайшаан, эрхэмлэн үздэг байжээ. Эрдэм чадалтныг өөртөө татаж, төрийг оюуны хүч, арга ухаанаар засан тохинуулахыг чухалчлан өтгөс өвгөдийн үгийг хэрэглэн төрийн үйлийг төвхнүүлэхэд түшиг тулгуур болгож өгүүлсэн бүгдийг “хойдод хууль болтугай” хэмээн зарлигласан тул “Чингис хаан билиг сургаал”-д үе үеийн мэргэдийн оюун ухаан шингэсэн байдаг.

Мөн Хэрэйд, Найман зэрэг нэлээд соёлжсон Монгол аймаг, улсуудад хүчин зүтгэж байсан Чинхай, Хадаг, Тататунгаа нар тэргүүтэй эрдэмтэн мэргэдийг өөрийн дэргэд авч, хөвгүүд дүү нартаа бичиг үсэг заалгахаас эхлээд хишигтнийг ялгаж томилох тухай зарлиг буулгахдаа: “Миний хишигтнийг томилоход түмт, мянгат, зуутын ноёдын хөвгүүд, сул чөлөөт хүний хөвүүдийн дотроос миний дэргэд тэнцэх билиг эрдэмтэй, бие сайтайгий нь оруултугай”⁶ [МНТ §224] гэсэн нь эрдэм авъяасыг хир чухалчлан үздэг байсныг илтгэнэ.

Чингис хаан үнэнч шударга, эрдэм билиг төгс, төрийн үйлийг төвхнүүлэхэд түшиг тулгуур болж чадах нэгэн байх аваас, эзлэн авсан харь орны иргэн ард байсан ч гэлээ дотно шадарлан, хаан төрийн хүндтэй албанд тохоон томилдог байжээ. Үүний тод жишээ бол Монгол хаадын алдарт Хятан зөвлөх Елюй Чуцай юм. Тэрээр Чингис, Өгэдэй хаадын дэргэд гуч гаруй жил Их Монгол улсын төрд үнэнчээр зүтгэж, “Морин дэл дээрээс тогтоосон улс гүрнийг морин дэл дээрээс төвхнүүлж болохгүйн”^{7,8} учрыг тайлбарлаж, суурьшмал ард иргэнийг засан тохинуулах арга ухааныг зааж зөвлөж байсан ажээ [Ш.Чоймаа, 2012, 136]⁹.

Елюй Чуцай¹⁰, Чан Чунь арш нарын зэрэг харь орны эрдэмтэн мэргэд, аянчин гийчин, гар урчууд, худалдаа наймаачидтай дотно нөхөрлөж, ивээн тэтгэж, дэлхий

⁴ Мөн тэнд

⁵ Ш.Чоймаа, Б.Батбаяр (2015), Арван буянт номын цагаан түүх, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, III боть, эхийг хөрвүүлж буулгаж, тайлбар хийв, Улаанбаатар, 58-р тал.

⁶ Ц.Дамдинсүрэн (1990), Монголын нууц товчоон, Улаанбаатар, 187-р тал.

⁷ Ш.Бира (2001), Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа, III, Улаанбаатар, 281-р тал.

⁸ Рашпунцагийн “Болор эрих”-ийн 156-р талд, Елюй Чуцайн “Дэлхий дахиныг хэдий морины явсаар оловч, морины дээрээс засваас үл больюу” хэмээн Тайзу (Чингис)-д айлтгаж, хаан тэр үгийг маш зөвшөөн, улмаар бичгийн сайдыг хэрэглэлээ гэж бичжээ.

⁹ Ш.Чоймаа (2012), Тэмүжин хөвгүүнээс тэнгэрлэг эзэнд, Улаанбаатар, 136-р тал.

¹⁰ “Урт сахалт” хэмээн алдаршсан Елюй Чуцай Хятадаар. 耶律楚材, пиньинь: Yǐlǜ Chǔcái нь Хятан буюу Кидан аймгийн эрдэмтэн Ила Люйн хүү болон 1189 оны 8-р сарын 3-ны өдөр хорвоод мэндэлжээ. Тэрээр Илагийн гурван хатны бага хатан Яншигаас төрсөн гурав дахь хүү нь бөгөөд түүний удам угсаа нь: Хятан гүрний Ляо улсыг үндэслэгчдийн нэг Абаози буюу Елюй нь Амбагай хааны ес дэх үеийн ач хүү ажээ. Чингис хаан Зүрчидийн Алтан улсыг дайлаар мордох үед буюу 1218 оны хавар Елюй Чуцайг өргөөндөө дуудан эрдэм мэдлэг, оюун ухааныг нь хүндлэн биширч түүний зөвлөгөөг авах болсон. Монголын эзэнт гүрний төрийн түшээ, одон зурхайч Елюй Чуцай 1219–1224 онд дундад Азид хийсэн аян дайнд биеэр оролцож дайран өнгөрсөн нутаг орны газарзүйн онцлог, ёс заншлийн талаар “Өрнө зүгт аялсан шастир” хэмээх бүтээлээ туурвижээ. Монголын эзэнт гүрний өргөн уудам нутаг дэвсгэр болон өөр улс оронд цаг мөч адилгүй байдлыг тогтоож цагийг зөрүүг тодорхойлохын тулд газарзүйн уртрагийн тухай ойлголтыг өөрийн бүтээлдээ хөнджээ. Судлаачид Елюй Чуцайг Чуу мэргэн мөн гэсэн байдаг. Тухайлбал, Ц.Дамдинсүрэн абугай “МУЗ-ын тойм номын 80-р талд “Чуу мэргэн бол мэргэн сайд Елүй Чуцай мөн” гэсэн. Өвөрмонголын эрдэмтэн Чойжи 1984 онд хэвлүүлсэн “Алтан товч” номын 221-р талын 1-р

дэхиний өв соёл, үүх түүх, элдэв сонин хачинг сонордон болгоож, шүүн тунгааж, бясалган боловсруулж, сэтгэлд нийцсэн, зохист үгийг өөрийн билиг оюундаа шингээн авч, сургаал айлдвартаа холбон сэлбэн өгүүлдэг байжээ.

90b 28 *erdem-tübilig-tü-yiolbasu*:

90b 29 *erdeniögčüolumlандuran-iinu*

90b 30 *abubasuäčitusainu tan*

91a 1 *-tur yekebolqu*

91a 12 *bikemensedkitele: bilig-iyen*

91a 13 *toytaγaydaqui*[Лувсанданзан, 1990, 90b 28-91a 13]¹¹ гэсэн сургаалд эрдэм чадалтныг өөртөө татаж, төрийг оюуны хүч, арга ухаанаар засан тохинуулахыг дэлхий дэхиний их хаадууд чухалчлан байсны гэрч нотолгоо билээ.

Мөн Чингис хаан Чан Чунь¹² бомбо¹³ -ыг урин залж¹⁴, *сургаал айлдварыг хичээнгүйлэн сонсож, хөх дэвтэртээ тэмдэглэн хадгалж*, түүний эрдэм чадвар, оюун билгийг төр засах, тэгшлэх үйл хэрэгтээ ашиглан хэрэглэж байжээ. [Ли Жичан, 2010, 18-20]¹⁵.

Ийнхүү эзэн Чингис хаан холын хүнээс үг сонсож, дэлхий ертөнцийг өөрийн төсөөлөлдөө багтаан хүн төрөлхтөний оюуны өв сангаас суралцахыг хичээж эрдэм билигтнийг дотночлон, сэцэн мэргэн үгсийг нь оюундаа тунгаан төрийг арга, ухаанаар жолоодох, өтгөс нялхасыг амар амгалан байлгахыг хичээнгүйлэн хүсэмжилж байжээ.

Чингис хаантанд Елюй Чуцай нэгэнтээ “*Морин дэл дээрээс төрийг байгуулах амархан, харин мориноос буугаад төрийг төвиштгөх бэрхтэй*” хэмээн өгүүлсэн нь дайн тулалдаанд ялалт ялагдал хүлээх нь хоромхон зуурын хэрэг байдаг бол харин

тайлбарт “Чуу мэргэн хэмээгч нь даруй Чингис хаан ба Өгэдэй хааны үед төрийн зүтгэлтэн явсан Евлүй Чүсэй магад мөн” гээд үүнийгээ нотлон өгүүлсэн. Америкийн монголч эрдэмтэн өвөрмонгол Загчидсэцэн Ц.Дамдинсүрэн гуайн Чуу мэргэн Елү Чуцай гэснийг “үндэс баримтгүй” гэж өгүүлснийг дурдсан. Ш.Гаадамба “МНТ-ны судлалын зарим асуудал” номынхоо 196-р талд “Чуу мэргэн бол мэргэн сайд Елүй Чуцай мөн гэж баталсан нь баримтаас үзвэл хараахан ташаарсан зүйл бололтой” гэж тэмдэглэжээ.

¹¹ Lubsangdanjin, *Erten-ü qad-un ündüsülegsen törü yosun-u jokiyal-i tobčilan quriyaysan altan tobči kemekü orusibai*. Orusil bičigsen Ša.Bira, Ulus-un töb nom-un sang-dur qadayalaydaju bui Lubsangdanjin-u yar bičimel eke-eče gerel jiruy beledkegsen So.Törübatu, Ulus-un keblel-ün yajar, Ulaγanbayatur, 1990, 90b 28-91a13.

¹² Чан Чунь бомбо аршийн овог нь Цю, нэр нь Чузи, өргөсөн нэр Тунми. 1148 онд Хятадын Шаньдун мужид төрсөн бөгөөд Даосын шашны Чуаньзиндао урсгалын долоон тэргүүлэгчдийн нэг юм. Тэрбээр Даогийн сургаалыг залгамжлагчдын дунд төдийгүй буддист болон күнзийнхний дунд асар их алдаршсан даяанч байжээ. Чан Чунь гэдэг нь “Мөнх хавар, мөнхийн цэл залуу” гэсэн утгатай үг. Тэрээр 1227 онд жанч халжээ. “Чан Чунь бомбын баруунш зорчсон тэмдэглэл” зохиолоос гадна Чингис хаанаас Чан Чунь бомбыг урьсан захидлууд, Чан Чунь бомбоос Чингис хаанд илгээсэн захидал, Чингис хаанаас Чан Чунь бомбод илгээсэн захидал, зарлиг зэрэг хэд хэдэн материал одоогоор олдож судалгааны эргэлтэд ороод байгаа юм.

¹³ Бомбо: Нангиадын ард түмний оюуны соёлын нэгэн их ололт бол эртний хятадын гүн ухааны сургаал болох Даогийн ёс буюу монголчууд Бомбо /Бумба/-ын суртал, Бомбын ёс, Бомбын шашин хэмээн нэршсээр иржээ. Даосизм нь ертөнцийн зүй зохицол, хорвоогийн жам ёстой үл тэрслэн, хүмүүний амьдралыг жаргалтай туулах тухай сургаал юм. Гол бүтээл нь “Дао дэ зинь” буюу “Зам мөрийн судар” бөгөөд Лаоз зохиосон гэдэг.

¹⁴ Чан Чунь бомбо 1222 оны хар морин жил эзэнд бараалхан жил тойрон орчлонгийн элдэв сонин, эрдэм ухааныг ярилцсаар 1223 оны дөрөвдүгээр сарын 12-нд нутгийн зүг хөлгийн жолоо залжээ. Түүнийг нутагтаа харьсаны дараа Чингис хаан хэдэнтээ захидал илгээж улс, гэрийг засах тухай зөвлөлдөж байсан баримт бий.

¹⁵ Я.Ганбаатар, Ц.Ганбаатар (2010), Ли Жичан, Чанчунь бомбын өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл, Орчуулж тайлбарлав, Улаанбаатар, 18-20-р тал.

төрийг энхжүүлэн тогтоож барих нь алс хэтийн, өнө мөнхийн, хүнд сорилт, хүчир ажил болохыг хэлсэн хэрэг юм. Чингис хаан өтгөс өвгөдийн үгийг сонсож, төрийн үйлийг төвхнүүлэхэд түшиг тулгуур болгон хэрэглэж зовон зүдэн, зөөж хураасныг гагцхүү оюуны хүчээр хурааж болохыг мэддэг байжээ. Уул дагаж мод, өвгөд дагаж ухаан гэдэгчлэн туулсан амьдралын гашуун сургамж, туршлага, арга ухаанаар аливаад хандах чухалтайг хэлжээ. Ийнхүү эрдэм билигтнийг эрдэнэ өгч оломлон дурыг нь аван сэцдийн зөвлөл байгуулж улс төр, цэргийн шийдвэрүүдийг хэлэлцүүлж байсан нь эртний Монголчуудын улс төрийн соёлын нэгэн өвөрмөц онцлог байв. Цэрэг байлдааны шийдвэрийг эхлээд алтан ургийнхан, сэцдийн зөвлөл гаргадаг байв. Сэцэд мэргэд юуны өмнө *“Хан их төрийн хэргийг зөвлөх”, “сайн мууг ялган хэлэлцэх”* буюу зарга шүүх үүрэгтэй байжээ.

Сэц булаалдах гэдэг нь шүлэглэх, яруу тод хэлж ярьж, марган мэтгэлцэхийг хэлдэг. XIII зууны үеийн Монголчуудын мэтгэлцээний гайхамшигт жишээ бол *“Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвүүн цэцэлсэн шастир”* бөгөөд Чингис хаан есөн өрлөгтэй үг хэлэлцэн гартааж буй өнчин хөвгүүнийг бага буурай гэж гололгүй цэцэн билгийг нь ихэд үнэлж байгаагаар өгүүлдэг.

Учир зүйг мэдвэл мэргэн

Ухаан санааг бүртгэвэл сэцэн гэсэн ардын зүйр үг нь мэргэн сэцний учрыг гойд сайн ялган тодорхойлж байна.

Хүн хэдийгээр цэцэн төрөвч

Сургуулиас ангид мэргэн үл болмуй хэмээн аливаа хүн төрөлхийн хурц ухаан, сэцэн мэргэн байлаа ч гэсэн зайлшгүй бусдын сургаал сургамжийг хүртэж байж, сая алс хэтийг харж, гүнийг сэтгэж чадна гэдгийг хэлжээ.

Аливаа улс орны мандал бадрал, хөгжил цэцэглэлт, хүчирхэг тусгаар байдалд төрийн жолоодож буй түшмэл, сэцэд, удирдагч нарын эрдэм чадал, оюун билиг, алс хэтийг харах мэргэн ухаан, буруу зөвийг ялгах хурц хараа, алагчлах үгүй сэтгэл, албат иргэдээ энэрэн нигүүсгэх ууч холч ухаан зэрэг төрийн хүмүүнд бүрдсэн шинж төрх чухал болохыг

Төрийн эзэн хаан цэцэн мэргэн болбоос

Төрүүлсэн эцэг эх бүтэн болбоос

Төрөлдсөн ах дүү бүрэн болбоос

Төр ёсыг мэдэгч түшмэл болбоос

Түрэмгий дайсныг дарагч цэрэгт болбоос

Төв анх учирсан гэргий ба хөвгүүн үр мэт болбоос

Түгээмэл эрхэт тэнгэр ивээх бөгөөс

Төвшин их жаргал тэр буй [Болор эрих, 74]¹⁶ хэмээн Чингис хаан зарлиг болсон нь учиртай билээ.

Их Монгол улс дэлхийн талыг эзэгнэн хүчирхэг болсон хүчин зүйлүүдийн нэг нь “эрдэм ухаан, оюуны хүч” юм. Эцэг өвгөдийн соёсон сургаал айлдварыг эрхэмлэж, эрдэм ухааныг дээдэлж, эв нэгдлийг чанадлан сахиж, зориг зүрхийг бадрааж, шантралгүй нэгэн сэтгэлээр хатуужин зүтгэж нэгэн багц сум адил үл дийлдэх их улсыг байгуулсан түүхтэй билээ.

¹⁶ М.Баярсайхан, Ч.Нэргүй, Д.Бүдсүрэн (2006), Рашпунцаг, Болор эрхи, харгуулан хөрвүүлэв, Улаанбаатар, 74-р тал

Алтан ургийнхны дотроос хамгийн ухаантай эрдэмтэй, билиг сургаалыг явдал мөрдөө хэрэгжүүлдэг хүн хаан төрийг барих, чингэхдээ тэр хүн хамгийн эрдэм мэдлэгтэй хүмүүсийг сонгон авч төрд зүтгүүлэх учиртай болохыг айлдан зовон төвхнүүлэн зассан төр ёс минь сахин хадгалах хамгаас хэцүү, сахин эс хатуужваас тарж бутрах аюул буй бүтээснээс сахисан минь дээр, сахихдаа өтгөс өвгөдийн соён сургасан гүн утгат үгсийг бишрэн шүтэж, эрдэмт хүмүүнийг эрхэмлэн дээдлэж, төрийг оюуны хүч, арга ухаанаар засан тохинуулахын чухлыг сургажээ. Чингис хаан өтгөс өвгөдийн үгийг сонсож, төрийн үйлийг төвхнүүлэхэд түшиг тулгуур болгож

Бие баатар болбоос нэгэн үеийн баатар буюу

Билиг баатар болбоос түмэн үеийн баатар буюу

хэмээн биеийн хүчнээс оюуны хүч (билигт үгс)-ийг чухалчлах үзлийн тод гэрч билээ.

Эрдэм ухааныг дээдлэн, өвгөдийн сургаал айлдварыг ёсчлон дагаж, хуульчлан баримталж, хувирган өөрчлөх, гуйвуулан мушгихийг ихэд цээрлэн засаг хууль гаргаж байжээ. Хаан төрийн эрхэмлэн дээдлэх ёстой үнэт оюуны өвийг зөвөөр тодорхойлсоноор эд хөрөнгөнд шунах бус эрдэм ном, оюун билгийг шүтэж улс орноо хүчирхэг байлгах гол аргыг эзэмшсэнд буй.

Чингис хааны дараа Өгэдэй хаан, түүний дараа Гүег хаан, Мөнх хаан, Хубилай тус тус хаан ширээ залгамжилжээ. *Тэдгээрийн дотроос хамгийн аугаа их, хамгийн хүчирхэг нь Хубилай хаан бөгөөд тэрбээр түрүүчийн хаадуудыг хамтатгаснаас ч суу хүчин нь давуу болой. Тэгээд ч энэ ертөнцийн бүх эзэн хаад, бүх христостон болон сарацин нарын хаад ч элбээд хүч хүрч хийж эс чадах тийм үйл хэргийг их хаан Хубилай бүтээж чадсан бөлгөө*¹⁷ гэж Марко Поло аян замын тэмдэглэлдээ бичжээ. Хубилай хааны үед Их Юан улс хүчирхэг байсаны гол үндэс нь эрдэм ном, оюун билиг, эрдэмтэн мэргэдийг тэтгэн дэмжиж төрийг жолоодох арга ухаан болгон хэрэглэж Ази тивийн ихэнх талыг өөрийн харьяанд оруулан захирч чадсанаар түүхэнд “Сэцэн хаан” хэмээн алдаршсан билээ.

Гүюг, Мөнх, Хубилай нарын Монголын их хаад эцэг өвгөдийн гэрээслэлд үнэнч, хаан төрийн хатуу ёс журмыг дээдлэн

Цэцэн сайд улсын эрдэнэ

Мэргэн эм гэрийн эрдэнэ

Баатар жанжсин цэргийн эрдэнэ

Багтаамжит хөвгүүн гэрийн эрдэнэ

хэмээн Чингис өвөг нь сургаж байсныг ёсчлон биелүүлж явсан тул Монголчууд хүчирхэгжиж мандсан алтан үе байжээ.

Ийнхүү өтгөс өвгөдийн гүн утгат үгс, захиа гэрээсийг хичээнгүйлэн сонсож, учир утгыг нь ухааран ойлгож, чандлан баримталдаг хүн л удирдагч болж, эрдэмт хүмүүнийг эрхэмлэн дээдлэж, төрийг оюуны хүч, уран арга ухаанаар засан тохинуулахын чухлыг эрхэмлэдэг байсан төдийгүй их хаан ор залгамжлахад гол шалгуур болгодог байсан нь төр ёсны үйл хэрэгт маш чухал үүрэгтэйг гэрчилнэ. Энэхүү эртний сайхан уламжлалаа эргэн харж, санан сэхээрч, ухамсарлан ойлгож, улсаа улсын дайтай болохыг тулд бид хэнийг төрийн түшээдээр сонгох ёстой вэ? хэмээн бодолцох цаг болжээ.

¹⁷ Улсын хэвлэлийн газар (1987), Марко Поло, Орчлонгийн элдэв сонин, Улаанбаатар, 84-182-р тал.

НОМЗҮЙ

1. Владимирцов Б.Я. (2001), Чингис хаан, Улаанбаатар.
2. Волфрум П. (2007), Чингис хаан хийгээд түүний өв, Улаанбаатар.
3. Ч.Далай (1994), Монголын түүх (Их Монгол улс 1206-1260), Дэд дэвтэр, Улаанбаатар.
4. С.Дулам (2013), Монгол соёл иргэншлийн утга тайлал, Улаанбаатар.
5. С.Дулам (2006), Чингис хааны төрийн бэлгэдэл, Улаанбаатар.
6. Д.Наран (2001), Монголын төр ёсны боловсролын түүх, Улаанбаатар.
7. Ш.Чоймаа (2012), Тэмүжин хөвгүүнээс тэнгэрлэг эзэнд, Улаанбаатар.
8. А.Цанжид (2011), Төр барихуй монгол ухаан, Улаанбаатар.

ABSTRACT

An ancient time, those who were to become the leaders of the state not only diligently learned applied wisdom and knowledge, but admired and followed the insight and education that their ancestors had imparted them with, respected those who possessed high intellect and commanded the state by combining intelligence with cunning; a proven statement as mental acuteness was the most prominent criteria in inheriting the state. In fact, during the rule of Ugudei and Khubilai who were adoring wisdom as a state main policy, Mongolian state was more powerful.